



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 1/100

Жаргалтхаан сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхээ шилжүүлэх тухай хүсэлт ирүүлсэн иргэн Данзангийн Энхээ (СМ62010615)-ийн хүсэлтийг судлан үзээд, Жаргалтхаан сумын 4 дүгээр баг Чулуут, Байцын Нацаг /Сагсайн толгой/ хаягт байрлах, 2319002686 нэгж талбарын дугаартай, өвөлжөө, хаваржааны зориулалттай 10000 квадрат метр газрын эзэмших эрхийг иргэн Дагдандоржийн Амгаланбаатар (СЭ80111711)-д шилжүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэхийг газар эзэмшигчид даалгасугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэхийг сумын газрын даамал (Н. Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжтай холбогдуулан иргэн Д. Энхээгийн эзэмшлийн 0000386845 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С. ГАНБАТ